

АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ХӨНГӨЛӨЛТ ЭДЛЭХ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, ТӨСӨЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9.8-д заасан шинжлэх ухааны академид судалгаа, шинжилгээний зориулалтаар олгосон тэтгэлгийн хүрээнд татварын хөнгөлөлтөд хамрагдах бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тодорхойлох, түүнд хяналт тавих үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд энэхүү шаардлагыг баримтална.

Хоёр. Татварын хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах нийтлэг шаардлага

2.1.Хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд оруулсан хөрөнгө оруулалт нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.1.1.татвар төлөгчийн нийгмийн хариуцлагын хүрээнд Монгол Улсын нутаг дэвсгэрт өөрийн, эсхүл өөр хуулийн этгээдийн элэгдэл тооцох үндсэн хөрөнгөд оруулсан бодитой хөрөнгө оруулалт байх;

2.1.2.татвар төлөгчийн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 8.1, 8.5-д заасан үндсэн үйл ажиллагаатай хамааралгүй байх;

2.1.3.татвар төлөгчийн өөрийн хэрэгжүүлэх бүтээн байгуулалт, төслийн хувьд тухайн татвар төлөгчийн удирдах дээд байгууллагын баталсан бизнесийн төлөвлөгөөнд туссан, санхүүгийн тайланд элэгдэл тооцох үндсэн хөрөнгөөр бүртгэгдсэн байх;

2.1.4.татвар төлөгч бусад этгээдэд хөрөнгө оруулалт хийх тохиолдолд тухайн этгээдтэй төсөл, үйл ажиллагаанд нь хөрөнгө оруулалт хийх гэрээ байгуулж, нотариатаар гэрчлүүлж, хөрөнгө оруулалт авч буй талын санхүүгийн тайланд элэгдэл тооцох үндсэн хөрөнгөөр бүртгэгдсэн байх.

2.2.Шинжлэх ухааны академид судалгаа, шинжилгээний зориулалтаар олгосон тэтгэлэг нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.2.1.хариу төлбөргүй шилжүүлсэн мөнгөн хөрөнгө байх;

2.2.2.тэтгэлэг хүлээн авч буй этгээд нь тэтгэлэг өгөх татвар төлөгчтэй Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлд заасан харилцан хамааралгүй байх;

2.2.3.Иргэний хуульд заасныг баримтлан тэтгэлгийн зориулалтыг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9-д нийцүүлэн тусгасан гэрээ байгуулж, нотариатаар гэрчлүүлсэн байх;

2.2.4.тэтгэлэг олгосон болон хүлээн авсан этгээд нь тухайн тэтгэлгийг энэхүү шаардлагын 2.2.3-т заасан гэрээнд тусгасан зориулалтын дагуу тухайн тайлант хугацаанд зарцуулсан гэдгийг хүлээн зөвшөөрч, гэрээг

цуцлах болон татгалзахгүй тухайгаа илэрхийлсэн акт үйлдэж, нотариатаар гэрчлүүлсэн байх;

2.2.5. тэтгэлгийн зардал нь Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтаар баталгаажсан байх.

2.3. Энэ шаардлагын 2.1, 2.2-т заасан тэтгэлэг нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13.1.1, 13.1.3, 13.1.4, 13.1.5-д заасан хасагдах зардлын шаардлагыг хангасан байна.

2.4. Бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаа нь шаардлагын хавсралтад заасан бусад шаардлагыг хангасан байна.

Гурав. Албан татварын хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаа

3.1. Шинжлэх ухааны академид судалгаа, шинжилгээний зориулалтаар олгосон тэтгэлэгт дараах төсөл, үйл ажиллагааг хамруулна. Үүнд:

3.1.1. Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 3.1.8-д заасан суурь судалгаа;

3.1.2. Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 3.1.9-д заасан хэрэглээний судалгаа;

3.1.3. Инновацийн тухай хуулийн 3.1.9-д заасан технологийн туршилт, зүгшрүүлэлт;

3.1.4. Инновацийн тухай хуулийн 3.1.1-д заасан инноваци;

3.1.5. Судлаачийн тэтгэлэг.

Дөрөв. Бусад

4.1. Аж ахуйн нэгж нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.9 дэх хэсгийг татвараас зайлсхийх үндсэн зорилгоор ашигласан тохиолдолд татварын холбогдох хуульд заасны дагуу хөнгөлөлт эдлүүлэх үндэслэл болохгүй.

4.2. Аж ахуйн нэгжийн оруулсан тэтгэлэг нь нь нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулагдаагүй, гэрээний хэрэгжилт хангагдаагүй нь тогтоогдсон тохиолдолд татварын холбогдох хуульд заасны дагуу хөнгөлөлт эдлүүлэх үндэслэл болохгүй.

Хавсралт. Бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах бусад шаардлага

№	Татварын хөнгөлөлт олгох чиглэл	Зориулалт	Төрөл	Тусгай шаардлага	Тавигдах доод шаардлага
1	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9.8. Шинжлэх ухааны академид судалгаа, шинжилгээний зориулалтаар олгосон тэтгэлэг	Тэтгэлэг	Суурь судалгаа	- Шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан тухайн эрдэм шинжилгээний байгууллагын судалгааны үндсэн чиглэл, эсхүл - Засгийн газрын тогтоолоор баталсан "Шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, цөм технологи"-той нийцсэн байна.	- Тэтгэлгийн хэмжээ нь тухайн санаачлан хэрэгжүүлэх судалгаа, шинжилгээний төслийн дүнгээр байна. - Тухайн эрдэм шинжилгээний байгууллагын үндсэн орон тооны эрдэм шинжилгээний ажилчид гүйцэтгэсэн байна. - Судалгаанд зориулж багаж, тоног төхөөрөмж худалдан авсан тохиолдолд тухайн эрдэм шинжилгээний байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэсэн байна.
			Хэрэглээний судалгаа		
			Технологийн туршилт, зүгшрүүлэлт;	Засгийн газрын тогтоолоор батлагдсан "Инновацын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл"-тэй нийцсэн байна.	
			Инновац		
Судлаачийн тэтгэлэг	WoS-д бүртгэлтэй олон улсын хянан магадлал бүхий мэргэжлийн сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн судлаач байна.	Тухайн эрдэм шинжилгээний байгууллагын үндсэн орон тооны эрдэм шинжилгээний ажилтан байна.			